
Гадаадын иргэн ковид-19-ийн үнэгүй шинжилгээ өгөх зааварчилгаа

Хэн ч байсан халдвар авч болно, өөрийн мэдэлгүй хайртай гэр бүл болон ойр орчмын хүмүүст халдвар тарааж болно.

- Гадаадын иргэн танд ковид-19 халдварын шинж тэмдэг илэрвэл заавал шинжилгээ өгөөрэй.
- Хэн ч байсан халдвар авах магадлалтай, өөрийн мэдэлгүй хайртай гэр бүлдээ халдвар тараах талтай учраас шинж тэмдэг илрээгүй байсан ч шинжилгээнд хамрагдаарай.

Хууль бусаар оршин суугаа гадаадын иргэн гэдэг шалтгаанаар айдас түгшүүртэй байна уу?

Айж эмээх зүйлгүйгээр үнэгүй шинжилгээнд хамрагдаарай!

- Оршин суух хугацаа нь хэтэрсэн хууль бусаар оршин суугаа гадаадын иргэн виз-ний ангилал хамаарахгүйгээр үнэгүй ковид-19-ийн шинжилгээ өгөх боломжтой бөгөөд түргэвчилсэн шинжилгээ өгөх цэгүүдэд айж эмээх зүйлгүйгээр шинжилгээнд хамрагдаарай.
- Эрүүл мэндийн байгууллагад өгсөн хувийн мэдээллийг зөвхөн халдварт өвчин сэргийлэх зорилгоор ашиглах ба Хууль зүйн яамнаас хууль бусаар оршин суугаа гэдэг шалтгаанаар албадан барьж хорихгүй.

Өөрт ойр шинжилгээ өгөх цэгийг мэдэхийг хүсвэл 1339, орчуулагч хэрэгтэй бол 1345 эсвэл 1330

- Ойр байгаа түргэвчилсэн шинжилгээ өгөх цэгийг мэдэхийг хүсвэл **Эмгэг судлалын ерөнхий газрын лавлах**(1339), орчуулагч хэрэгтэй бол **Хууль зүйн яам** Гадаад и

ргэдийн нэгдсэн зөвлөгөө өгөх төвд(1345) хандах эсвэл Аялал жуулчлалын лавлах төв(1330)-өөс асуух боломжтой.

Утасны дугаар	Ажлын цаг	Зөвлөгөө болон орчуулга хийх хэл
(☎1345) Хууль зүйн яам Гадаад иргэдийн нэгдсэн лавлах төв	24цаг 09:00~18:00	Англи, Хятад хэл Япон, Вьетнам, Тайланд, Индонез, Орос, Монгол, Бангладеш, Пакистан, Непал, Камбож, Мьянмар, Франц, Герман, Испани, Филиппин, Араб, Шриланк хэл
(☎1577-0071) Хөдөлмөрийн яам Гадаад ажилчдад зөвлөгөө өгөх төв	09:00~18:00	Вьетнам, Филиппин(Англи), Тайланд(Лаос), Монгол, Индонез(Зүүн Тимор), Шриланк, Хятад, Узбекистан, Киргизстан, Пакистан, Камбож, Непал, Мьянмар, Бангладеш
(☎1330) Солонгосын Аялал Жуулчлалын газрын Аялал жуулчлалын лавлах төв	24цаг 08:00~19:00	Англи, Хятад, Япон хэл Вьетнам, Тайланд, Малайз/Индонез, Орос хэл



Хууль Зүйн Яам